

ОРОН НУТГИЙН ИХ ДЭЭД СУРГУУЛИУДАД СУРАЛЦАЖ БАЙГАА ОЮУТНУУДЫН ЦАХИМ СУРГАЛТЫН ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Б.Хонгорзул¹, Б.Болортуяа¹, Ц.Болормаа¹, Э.Мөнхчимэг¹, Э.Энхзаяа¹,
Т.Буяндэлгэр², Р.Минжирмаа², Т.Гантулга³, Б.Доржпүрэв³ Б.Хандаа¹, У.Баттамир¹

¹АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС

²Ховд Их Сургууль

³Дорнод Их Сургууль

khongorzul.b@mnums.edu.mn

Хураангуй

Цахим сургалтын үр дүн нь оюутны сурах арга барил, сургалтын материалын чанар, сургалтын зохион байгуулалт болон хэрэглэж буй технологийн шийдлээс хамаардаг. Түүнчлэн цаашид сургалтын чанарыг илүү сайжруулахад оюутны сэтгэл ханамжийг тогтоох нь туйлын чухал юм. Иймээс бид цахим сургалтын талаарх оюутны сэтгэл ханамжийг тодорхойлж, түүнд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Судалгааг тоон болон чанарын судалгааны аргуудын ашиглан нэг агшингийн загвараар хийсэн. Судалгаанд оюутны сэтгэл ханамжийг тодорхойлох болон цахим сургалтад хамрагдахад тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох 17 асуулт бүхий асуумжийн хуудас ашигласан ба АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, Ховд Их Сургууль, Дорнод Их Сургуулийн цахим сургалтад хамрагдаж буй нийт 469 оюутныг хамруулан судаллаа. Оюутнуудын сэтгэл ханамжийг Ликертийн 5 онооны хэмжүүрээр тодорхойлоход 3.4 байв. Оюутны сэтгэл ханамжийн түвшинд цахим сургалтад хамрагдаж буй байршил болон суралцаж буй хөтөлбөрөөс хамааран статистикийн ач холбогдол бүхий ялгаа байлаа. Цахим сургалтад хамрагдахад хамгийн ихээр тулгамдаж буй асуудлуудад интернет сүлжээний хангалтгүй байдал болон цахим сургалтын материалын чанар, өмнө нь цахим сургалтад хамрагдаж байсан туршлага дутмаг байдал зэрэг нь нэрлэгдсэн байна.

Түлхүүр үг: бие даан суралцах чадвар, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Үндэслэл

Мэдээлэл, технологийн үсрэнгүй хөгжлийн өнөө үед хүн амд боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэх таатай орчинг бүрдүүлэх гол арга замуудын нэг нь цахим сургалт юм. Танхимын сургалттай харьцуулахад цахим сургалтад оролцогч нь өөрөө сурах орчноо бүрдүүлэх ба цахим сургалт нь хичээлийн цаг болон хичээлийн танхимаас үл хамааран суралцагчаас бие даан суралцах арга зүй, хувийн хариуцлага, хамтран суралцах ур чадвар зэргийг шаарддаг онцлогтой.

Цаг үеийн шаардлагад нийцүүлэн орон нутгийн сургуулиуд нь 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлын сургалтын үйл ажиллагааг цахим

хэлбэрээр зохион байгуулсан. Нийт оюутнуудын 9.6 хувь нь хотын төв, 52.1 хувь нь аймгийн төв, 21.1 хувь нь сумын төв, 17.2 хувь нь багийн төв болон хөдөөнөөс цахим хичээл судлаж байна. Судалгааны ажлын хүрээнд цахим сургалтын үйл ажиллагааны талаар оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлон тэдэнд тулгарч буй бэрхшээлүүдийг илрүүлэхийг зорилгоо.

Зорилго

Цахим сургалтын үйл ажиллагаа, зохион байгуулалт, явцын талаар орон нутгийн их дээд сургуулиудын оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлон тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх

Зорилт

1. Цахим сургалтын үйл ажиллагааны талаар оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох
2. Цахим сургалтын явцад оюутнуудад тулгарч буй бэрхшээлийг тодруулах

Судалгааны арга зүй

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, Ховд Их Сургууль, Дорнод Их Сургуулиудын оюутнуудаас нэг агшингийн загвар, тоон ба чанарын судалгааны аргаар судалгааг явууллаа. Судалгаанд 26 хөтөлбөрөөр суралцаж буй 469 оюутан хамрагдсан байна. Судалгааг нийт 17 асуулт бүхий асуумжаар 2020 оны 8-р сарын 24-нөөс 9-сарын 26-ны өдрүүдэд GoogleForm ашиглан цахим хэлбэрээр зохион байгууллаа. Судалгааны өгөгдөл мэдээлэлд SPSS программ ашиглан дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүн

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, Ховд Их Сургууль, Дорнод Их Сургуулиудад суралцаж байгаа цахим судалгаанд хамрагдсан оюутнуудын 79.3 хувь нь бакалаврын хөтөлбөр, 20.7 хувь нь техникийн боловсролын хөтөлбөрийн сургалтанд хамрагдаж байна.

Хүснэгт 1.


Судалгаанд оролцогчдын ерөнхий үзүүлэлтүүд		
Үзүүлэлт	n	n%
Оюутнуудыг суралцаж буй дамжаагаар үзүүлбэл		
1-р дамжаа	132	21.8
2-р дамжаа	159	33.9
3-р дамжаа	100	21.3
4-р дамжаа	78	16.3
Оюутнуудын одоогийн оршин суугаа газрын байршил		
Хот	45	9.6
Аймгийн төв	244	52.1
Сумын төв	99	21.1
Баг	81	17.2

Оюутнуудыг суралцаж буй дамжаагаар авч үзвэл 33.9 хувь нь 2-р дамжаа, 16.3 хувь нь 4-р дамжааны суралцагсад хамрагдсан байна. Оюутнуудын 52.1 хувь нь аймгийн төв, 9.6 хувь нь хотын төв, 38.3 хувь нь сумын төв болон багын төвөөс цахим сургалтанд оролцсон байна.



Зураг 1. Цахим хичээл судлах интернет орчин бүрдсэн байдал


Судалгаанд хамрагдсан оюутнуудаас цахим хичээлийг хоцрогдолгүй судлах интернэт орчин бүрдсэн эсэхийг тодруулахад 30.3 хувь нь цахим хичээл судлах интернэт орчин хангалттай бүрдсэн, 26.4 хувь нь цахим хичээл судлах цахим орчин нөхцөл бүрдээгүй гэж хариулсан байна.



Зураг 2. Оюутнуудын цахим хичээл судлахад зарцуулж буй хугацаа

Судалгаанд оролцсон оюутнуудын 60.2 хувь нь цахим онол, дадлага семинарын нэг хичээл

судлахад 32.4 хувь нь 30-60 минутын хугацаа зарцуулдаг бол 6 хувь нь 6 цагаас дээш хугацааг зарцуулсан байна.



Зураг 3. Цахим хичээл судлахад ашиглаж буй хэрэгсэл

Цахим онол, дадлага семинарын хичээл судлах, даалгавар, бие даалт гүйцэтгэхийн тулд нийт судалгааны оролцсон оюутнуудын 59.5 хувь нь гар утас, 31.1 хувь нь компьютер, 9.4 оюутан град ашиглаж байна.

Хүснэгт 2.

Цахим сургалтын талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин

Асуулт	Дундаж
Та цахимаар лекц, дадлага, семинарын хичээлүүдийн агуулгыг бүрэн ойлгож мэдлэг, ур чадвар эзэмшиж байгаа эсэх	3.1
Багш нар цахимаар илгээсэн хичээлтэй холбоотой унших материал, нэмэлт мэдээлэлээр хангаж байгаа эсэх	3.3
Цахим дадлага, семинарын хичээлийн даалгаварууд нь бие даан гүйцэтгэх боломжтой байгаа эсэх	3.2
Цахим хичээлтэй холбоотойгоор багш нар арга зүйн зөвлөгөө, тайлбар зааварчилгаа дэмжлэгийг хэрхэн үзүүлж байгаа эсэх	3.3
Цахим бие даалт, даалгавар гүйцэтгэх хугацаа хангалттай байгаа эсэх	3.2
Хичээлтэй холбоотой эх сурвалж мэдээлэлийг цахим орчиноос олж авч ашиглаж байгаа эсэх	3.2
Цахим хичээлүүдийн аудио, видео материалуудын дуу чанартай эсэх	3.6
Цахим хичээлүүдийн аудио, видео материалуудын дүрс чанартай эсэх	3.8
Цахим хичээлүүдийн аудио, видео материалуудын текст чанартай эсэх	3.7
Дундаж	3.4

Цахим сургалтын үйл ажиллагааны талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн үзүүлэлтээс харахад 3.1-3.8 байсан бөгөөд дундаж үзүүлэлт нь 3.4 буюу дунд зэрэг байна.

Хүснэгт 3.

Оюутнуудын сэтгэл ханамж, түүний хамаарлын үр дүн

Оюутны сэтгэл ханамжийг дамжаагаар харуулсан байдал					
1-р дамжаа	132	3.4232	.80423	3.2847	3.5617
2-р дамжаа	159	3.2624	.87554	3.1253	3.3995
3-р дамжаа	100	3.2936	.77602	3.1396	3.4476
4-р дамжаа	78	3.5876	.72008	3.4253	3.7500
Нийт	469	3.3684	.81634	3.2943	3.4425
Оюутны сэтгэл ханамжинд байршил хамаарсан байдал					
Хот	45	3.3074	.74412	.74412	3.5310
Аймгийн төв	244	3.7116	.67781	.67781	3.7971
Сумын төв	99	3.1655	.75061	.75061	3.3153
Баг	81	2.6163	.72330	.72330	2.7762
Нийт	469	3.3684	.81634	.81634	3.4425

Хүснэгт 3-аас харахад цахим сургалтанд хамрагдаж буй оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин оюутны цахим хичээл судлаж буй газрын байршил ($p=0.00$), суралцаж буй бол оюутнуудын суралцаж буй дамжаа ($p=0.02$) ач холбогдолтой байна.

Хүснэгт 4.

Оюутнуудын сэтгэл ханамж ба суралцаж буй хөтөлбөрийн хамаарал					
	Оюутны тоо	Дундаж	Стандарт хазайлт	95% итгэх интервал утга Доод утга	Р утга
Оюутны сэтгэл ханамжийг дамжаагаар харуулсан байдал					
Анагаахын суурь боловсрол	59.0	3.2	0.8	3.0	3.4
Сувилахуй	59.0	2.9	0.7	2.8	3.4
Эх барихуй	40.0	3.0	0.8	2.7	3.1
Сувилагч	40.0	2.7	0.8	2.4	3.2
Газрын тос	31.0	4.2	0.5	4.0	2.9
Нягтлан бодогч	23.0	4.1	0.5	3.9	4.4
Эм найруулагч	22.0	3.1	0.5	2.9	4.4
Уламжлалт анагаахын сувилагч	18.0	3.0	0.7	2.6	3.4
Бага ангийн багш	18.0	3.6	0.6	3.3	3.3
Сургуулийн өмнөх боловсрол	18.0	3.9	0.7	3.5	4.0
Лабораторийн техникч	17.0	2.6	0.7	2.2	4.2
Монгол хэлний багш	16.0	3.9	0.3	3.7	3.0
Хятад хэлний орчуулагч	15.0	3.8	0.4	3.6	4.0
Байгаль хамгаалагч	13.0	3.8	0.5	3.5	4.1
Гадаад хэлний багш	13.0	3.8	0.5	3.5	4.1
Биеийн тамирын багш	11.0	3.8	0.7	3.4	4.1
Байгалийн ухааны багш	11.0	3.6	0.4	3.4	4.3
Цахилгааны инженер	10.0	3.8	0.7	3.3	3.9
Мэдээлэл зүйн багш	10.0	3.9	0.4	3.6	4.4
Нийгмийн ажилтан	8.0	3.4	0.5	3.0	4.2
Нийгмийн багш	7.0	3.4	0.9	2.6	3.8
Дууны багш	4.0	4.0	0.6	2.9	4.2
Барилгын инженер	2.0	3.3	0.6		
Бизнес удирдлага	2.0	3.7	0.2		
Хөдөлгөөн засалч	1.0	2.5			
Урлаг судлаач	1.0	4.0			
Нийт	469	3.4	0.8	3.3	3.4

Хүснэгт 4-өөс харахад цахим сургалтанд хамрагдаж буй оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин сургалтын хөтөлбөр ($p=0.00$) үзүүлэлтийн хувьд статистик ач холбогдол ажиглагдсан.

Хүснэгт 5.

Цахим сургалтын талаарх нээлттэй асуултын үр дүн

Үзүүлэлт	Оюутны тоо	Хувь
1. Цахим хичээлийн техникийн чанар		
Хичээлийн дуу бичлэгийн чанар муу	14	2.9
2. Цахим хичээл явуулах арга зүй		
Лекцийн хичээл ойлгомжгүй	32	6.8
Цахим сургалтын чанар хангалтгүй, мэдлэг, чадвар эзэмшиж чадахгүй	25	5.3
Цахим груп нээж багштай харилцан ярилцах	9	1.9
Даалгавар хийх заавар ойлгомжгүй	10	2.1
Багш өөрийн биеэр хичээл зааж бичлэг хийх нь үр дүнтэй	11	2.3
Дадлагын хичээл ойлгомжгүй ур чадвар олгохгүй байна	8	1.7
Ном сурах бичгийг PDF-ээр оруулдаг	2	0.4
Багш нар эргэх холбоогүй байна	8	1.7
3. Цахим сургалтын орчин		
Хөдөө орон нутагт интернэт орчин хангалтгүй	63	13.4
Ном сурах бичиг зайлшгүй хэрэгцээтэй	33	7.1
Байнга дата авах хэрэгцээ гардаг, эдийн засгийн хувьд хүндрэлтэй байна	27	5.7
Техник хэрэгсэл муу /компьютер байхгүй, байнга утаснаас хичээл үзэх боломж муу байна/	26	5.5
Хичээл хийх орчин байхгүй /хөдөө мал төллөж байгаа, гэрийн орчин/	19	4.1
Хөдөөнөөс сүлжээтэй газар ордог учир цаг хугацаа, эдийн засгийн бэрхшээл байна	17	3.6
4. Цахим сургалтын бие даалт		
Нэг дор олон бие даалт, даалгаварыг хийх боломжгүй байна. Хугацаа давчуу байна.	36	7.6
Гүйцэтгэх боломжгүй даалгавар өгдөг /видео бичлэг хийх, PPP хийх гэх мэт/.	6	1.3
Даалгавараа эргэн мэдээлэх боломж муу байна. Утас, скайнер байхгүй.	4	0.8
5. Оюутны сурах арга барил		
Мэдээлэл хайх чадвар дутмаг байна	11	2.3
Сурах арга барил сайжирч байгаа	6	1.3
Хичээлийг цахимаар судлах нь боломжтой	100	21.3

Цахим сургалтын талаарх таны сэтгэгдэл гэсэн нээлттэй асуултанд оюутнуудын 21.3 хувь нь хичээлийг цахимаар судлах нь боломжтой гэж хариулсан байна. Харин цахим хичээлийн чанар хангалтгүй гэж 14 оюутан буюу 2.9 хувь, цахим сургалтын арга зүй хангалтгүй гэж 22.2 хувь, 39.1 хувь цахим хичээл хийх сургалтын орчин бүрдээгүй гэж дурьдсан байна. Цахим сургалтын бие даалтын төлөвлөлт нь хангалтгүй гэж 40 оюутан буюу 9.7 хувь нь дүгнэсэн байхад оюутны сурах арга барил болох цахим орчиноос мэдээлэл хайх, ашиглах чадвар дутмаг байна гэж 11 оюутан өөрийгөө үнэлсэн байна.

Дүгнэлт

Цахим сургалтын үйл ажиллагааны талаарх оюутны сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 3.4 буюу дунд зэрэг байна. Сэтгэл ханамж нь оюутны цахим хичээл судлаж байгаа байршил ($p=0.00$), суралцаж буй сургалтын хөтөлбөрөөс ($p=0.00$) хамааран статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Судалгаанд хамрагдсан оюутнууд цахим хэлбэрээр хичээлийг судлахад цахим хичээлийн орчин (интернэт орчин, ном сурах бичиг, тоног төхөөрөмж, суралцах орчин) бүрдээгүй гэж 39.1 хувь нь байгаа нь оюутан бүр жигд хүртээмжтэй оролцох боломжгүй байна. Мэдээлэл хайх чадвар 2.3 хувь нь дутмаг, 22.6 хувь нь хичээлийг цахимаар судлах боломжтой, сурах арга барил дээшилж байгаа гэж дүгнэсэн байна.

Ашигласан ном зүй

1. АШУҮИС, СБЗГ, Анагаах ухааны боловсрол судлал, УБ, 2018
2. АШУҮИС, Монголын анагаах ухааны боловсролын шинэчлэл, УБ, 2011
3. МАУБХ, Анагаах ухааны боловсрол, УБ, 2011
4. Сургалтын бодлого зохицуулалттай холбоотой дүрэм журмын эмхэтгэл (2019) АШУҮИС, СБЗГ, УБ,
5. С.Батхуяг, Б.Төртогтох, Н.Цогзолмаа, (2019) Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник, УБ,